

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Түнэл илч” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/031/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Давааням Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн аудитор: Б.Пүрэвсүрэн Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 03. 16 № 4/297.
танай _____-ны № _____-т

“ТҮНЭЛ ИЛЧ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЖАДАМБА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Түнэл илч” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Түнэл илч” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах материаллаг зөрчил илэрсэн. Үүнд:

Оны эцсийн 41,822.5 мянган төгрөгийн бараа материал, 620,450.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 662,273.3 мянган төгрөгийн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийгээгүй мөн 3,216.6 мянган төгрөгийн бараа материал, 85,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд тусгасан боловч биетээр байхгүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дүгээр зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1-т “өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах” зэрэг заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой, үнэлгээ ба хуваарилалт байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд 181,895.9 мянган төгрөгийн гадна дулааны шугам, 9,720.0 мянган төгрөгийн үнс баригч, 9,450.0 мянган төгрөгийн утаа

сорогч, 12,272.2 мянган төгрөгийн усны насос, 2,000.0 мянган төгрөгийн мотор зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 897,907.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 19,400.0 мянган төгрөгийн алдааг залруулж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 873,364.9 мянган төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 5,142.5 мянган төгрөгийн зөрчилд холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

“Түнэл илч” ХХК нь хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үнэ тарифыг шинэчлэн тогтоогоогүй, Хөвсгөл аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 04/23 дүгээр тогтоолоор баталсан халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг ашиглаж байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,352,826.08	881,431.30
1.1.2	Дансны авлага	2,056,839.70	48,211,411.11
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	39,665,461.05	42,083,065.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	48,075,126.83	91,175,908.14
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	472,965,847.29	620,450,855.36
1.2.2	Биет бус хөрөнгө	24,758,549.75	24,758,549.75
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	497,724,397.04	645,209,405.11
1.3	Нийт хөрөнгийн дүн	545,799,523.87	736,385,313.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	2,731,800.00	43,155,680.10
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	32,924,831.23	66,495,027.15
2.1.1.4	НДШ - ийн өглөг		5,576,826.58
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		13,151,029.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	35,656,631.23	128,378,562.83
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	19,404,507.44	19,404,507.44
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	19,404,507.44	19,404,507.44
2.2	Өр төлбөрийн нийт дүн	55,061,138.67	147,783,070.27
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	-	-
2.3.1	-төрийн	178,862,641.08	178,862,641.08
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	174,175,791.10	174,175,791.10
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	308,479,624.00	490,375,574.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(170,779,670.98)	(254,811,763.20)
2.3.11	Эздийн өмчийн дүн	490738,385.20	588,602,242.98
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	545,799,523.87	736,385,313.25

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	344,528,275.82	397,400,730.18
2	Борлуулалтын өртөг	378,140,556.86	428,276,500.25
3	Нийт ашиг (алдагдал)	(33,612,281.04)	(30,875,770.07)
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	24,395.35	19,043.58
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,491,408.05	662,393.60
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	26,631,223.00	53,785,055.00
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	32,939.55	52,704.33
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(58,760,640.19)	(84,032,092.22)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	(58,760,640.19)	(84,032,092.22)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(58,760,640.19)	(84,032,092.22)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(58,760,640.19)	(84,032,092.22)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.0	0.0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	178,862,641.1	174,175,791.1	293,679,624.0	-112,019,030.80	534,699,025.40
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0			0.00
2	Залруулсан үлдэгдэл		-			178,862,641.10
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0		-58,760,640.20	-58,760,640.20
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0			0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	14,800,000.0		14,800,000.00
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0			0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0			0.00
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	178,862,641	174,175,791	308,479,624	-170,779,671.00	490,738,385.20
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0			
2	Залруулсан үлдэгдэл		0.0			
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0		-84,032,092.22	-84,032,092.22
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0			0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	181,895,950.0		181,895,950.00
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0			0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0			0.00
8	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	178,862,641	174,175,791	490,375,574	-254,811,762.22	588,602,242.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	378,458,321.45	409,625,904.37
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	378,363,926.10	405,732,504.79
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	94,395.35	3,893,399.58
1.2	Мөнгөн зарлагын дүн	372,894,502.18	415,097,299.15
1.2.1	Ажиллагчдад төлсөн	105,685,212.00	164,323,252.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	37,363,542.79	47,616,838.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	54,463,675.00	64,651,127.40
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	52,358,810.55	49,640,908.51
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	87,594,350.00	61,639,628.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	23,124,746.49	13,352,591.12
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	12,304,165.35	13,872,953.72
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,563,819.27	(5,471,394.78)
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,563,819.27	(5,471,394.78)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	789,006.81	6,352,826.08
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	6,352,826.08	881,431.30

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Орлогын бүтэц	2025 оны төлөвлөгөө	2025 оны орлогын гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл ийн хувь
1	Төсөвт газар	385,993,728	389,498,968	3,505,240	101
2	Аж ахуйн нэгж	4,130,880	3,848,971	-281,909	93
3	Айл өрх	5,686,032	5,808,672	122,640	102
4	Хог тээвэр	6,600,000	529,100	-6,070,900	8
5	Халуун ус	7,000,000	893,637	-6,106,363	13
6	Цэвэр бохир ус	7,000,000	1,020,000	-5,980,000	15
7	Худаг	4,749,952	4,133,157	-616,795	87
Дүн		421,210,640	405,732,505	-15,428,087	96
1	Цалин	205,223,363.00	201,164,226.65	-4,059,136.35	98
2	НДШ	33,202,587.60	47,616,838.40	14,414,250.80	143
3	Албан томилолт	478,000	160,000	-318,000.00	33
4	Шуудан холбоо, хэвлэл захиалга	300,000	300,000	0.00	100
5	Бичиг хэрэг	650,000	410,227.20	-239,772.80	63
6	Хөдөлмөр хамгаалал	4,181,000	5,475,818	1,294,818.00	131
7	Урсгал засвар	6,627,500	6,077,909	-549,591.00	92
8	Түлш шатахуун	7,672,000	7,618,499.99	-53,500.01	99
9	Нүүрс	37,400,000	47,595,680	10,195,680.00	127
10	Нүүрс тээвэр	54,000,000	56,220,723	2,220,723.00	104
11	Нийт худалдан авах нүүрс	800		-800.00	0
12	Цахилгааны зардал	49,800,000	45,956,650	-3,843,350.00	92
13	Төлбөр хураамж	6,639,065	1,800,000	-4,839,065.00	27
14	Аудит	1,800,000		-1,800,000.00	0
15	ЭХЗЗ-ийн үйлчилгээний хөлс	1,171,821		-1,171,821.00	0
15	Агаарын бохирдолд	9,500		-9,500.00	0
16	Ус ашигласны төлбөр	160,000		-160,000.00	0
17	Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,476,480	369,000	-1,107,480.00	25
18	Тээврийн хэрэгслийн татвар	150,000		-150,000.00	0
19	Газрын төлбөр	56,264		-56,264.00	0
20	Банкны шимтгэл	15,000	50,800	35,800.00	339
21	ТУЗ-ын зардал	6,584,547		-6,584,547.00	0
Зардал		417,597,927.60	420,816,372.24	3,218,444.64	100.77
Ашиг ,алдагдал		3,612,712.40	-15,083,867.24		
Элэгдлийн зардал			-68,948,214.64		
Татварын дараах ашиг ,алдагдал			84,032,092.20		

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 897,907.4 мянган төгрөгийн 1 алдаа 9 зөрчил илэрснийг аудитын явцад 19,140.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,747.1 мянган төгрөгийн төлбөрийн акт , 106,034.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 770,985.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 878,767.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй учир “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно.

Залруулсан алдаа:

- Бараа материалын дансанд 19 140.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" -ын 6.Бараа материал "Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна" гэсэн заалтууд зөрчсөн ба зохистой ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэхүү үндсэн хөрөнгийн шинж чанартай 19,140.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдааг залруулсан.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд батлагдсан бизнес төлөвлөгөө хэрэгжээгүй, орлогын төлөвлөгөөг 23 809.9 мянган төгрөгөөр тасалж, зардлыг 63 792.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн 83 989.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан ажлын үр дүнг харгалзахгүй Компанийн гүйцэтгэх захирал Г.Жадамба оны эцэст 1 747.0 мянган төгрөгийн нэмэлт урамшуулал авсан байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.7-д "Энэ хуулийн 83.6-д заасан гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга/ гарын үсэг зурах бөгөөд гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна" Түнэл илч ХХК-ийн захиралтай байгуулсан гэрээний 4.3.1-д "Гэрээний хавсралтаар баталсан компанийн санхүү, үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтийн зорилтод түвшин, гэрээний үүрэг 100 хувь биелэлттэй хэрэгжсэн тохиолдолд компанийн тухайн жилийн нормативт цэвэр ашигаас давсан цэвэр ашгийн 10 хүртэл хувийг гүйцэтгэх удирдлагын багт жилд нэг удаа урамшуулал болгон олгоно" гэсэн заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 1 781.8 мянган төгрөгийн авлага, 41.413.8 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж

ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Авлага өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт: Шилэн дансанд 5 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд бүрэн гүйцэд мэдээллийг оруулаагүй байх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 620 450,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 41 822.5 мянган төгрөгийн бараа материалын дансанд тооллого хийгдэж тооцоо бодоогүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дүгээр зүйлийн 2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:"1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Шийдвэрлэсэн: Жилийн эцсийн тооллогыг хийж бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт: Шатахууны тооцооллыг шалгахад замын хуудас байхгүй, норм нормативыг тооцоолсон тооцоолол байхгүй тайлангийн хугацаанд 8 466.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 113.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" өсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5 дугаар зүйлийн 5.1.3. "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт: Явцын аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд биет тооллогыг хийхэд 3 216.6 мянган төгрөг бараа материал, 85.000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 53 833.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй машин тоног төхөөрөмж юунд ашиглагдаж байгаа, юу болох нь тодорхойгүй биетээр байхгүй бүртгэлд тусгагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1-т "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах" гэсэн заалт зөрчигдөж байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 94 079.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 19 нэр төрлийн 20 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалт зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансны тэг үлдэгдэлтэй хөрөнгийг шийдвэрлүүлэх.

2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийн хэмжээ цахим системээс 4280м.кв буюу 8 560.0 мянган төгрөгийн зөрүүтэй /илүү/ бүртгэгдсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1-т "үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх", 14 дүгээр зүйлийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт" зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийн бүртгэлийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр бүртгэлийг цэгцлэх.

3. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 3 395.5 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д "цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг үнэн зөв тайлагнаж татвар, нийгмийн даатгалтай тулгаж байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Үндсэн хөрөнгийн ангилал буруу тайлагнасан.	1	19,140.0			1	19,140.0	1	19,140.0		
Дүн	1	19,140.0			1	19,140.0	1	19,140.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны тооцоолол анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	8,466.7			1	8,466.7		
Шилэн дансанд мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	1	0			1	0		0
Биетээр байхгүй хөрөнгө бүртгэлд тусгагдсан.	1	57,049.9			1	57,049.9		
Авлага өглөгийн үлдэгдэл баталгаажуулаагүй	1	43,195.7			1	43,195.7		0
Бараа материал үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй	1	662,273.4			1	662,273.4		0
Үндсэн хөрөнгийн дансанд тэг үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэлтэй.	1	94,079.0					1	94,079.0
Биет бус хөрөнгийн бүртгэл зөрүүтэй	1	8,560.0					1	8,560.0
Цалингийн тооцоолол алдаатай	1	3,395.4					1	3,395.4
Урамшуулал илүү тооцож олгосон	1	1,747.0	1	1,747.0				
Дүн	9	878,767.4	1	1,747.0	5	770,985.7	3	106,034.4